



СҮХБААТАР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

7 давхарт, DG TOWER, Балдан-Осорын гудамж, 7-р баг
Баруун-Урт сум, 22075
Утас: 70518892 Факс: 70518892
Цахим шуудан: baigalorchin@sukhbaatar.gov.mn
Цахим хуудас: www.baigalorchin.su.gov.mn

2024.08.19 № 219

танай _____-ны № _____-т

Чиглэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 224 дүгээр тогтоолоор идлэг шонхор шувууг зөвхөн хоёр орны дипломат харилцааг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан гадаад орны төрийн өндөр, дээд түвшний албан тушаалтнуудад соёлын зориулалтаар 2024 онд бэлэглэх тоо хэмжээг баталсан.

Ерөнхийлөгчийн Тамгын Газраас ирүүлсэн хуваарь, жагсаалтын дагуу 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд “Зөвшөөрлийн тухай” хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.23-т заасны дагуу аймгийн Засаг даргатай гэрээ байгуулсан.


Байгалийн нөөц ашигласны төлбөрийг тус амьтны экологи, эдийн засгийн үнэлгээний 80%-иар тооцож, сумын БНАТ-ын дансанд, хураамжийг “Улсын тэмдэгтийн тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.35-д заасны дагуу 5%-иар тооцож, сумын татварын байцаагчаар нэхэмжлэл үүсгэн, гэрээнд заасан Б талаар төлбөрийг бүрэн төлүүлж, сумын байгаль хамгаалагч акт бичиж, ногоон зүүлт олгоно.

Гэрээний биелэлтэд хяналт тавьж, “Байгалийн нөөцийн ашигласны төлбөрийн тухай” хуулийн хэрэгжилтийн ханган, хяналт тавьж ажиллана уу.

Хавсралтаар:

1. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын А/548 дугаар тушаал
2. Аймгийн Засаг Даргын соёлын зориулалтаар идлэг шонхор шувуу бариулах зөвшөөрөл
3. Аймгийн Засаг Даргатай байгуулсан соёлын зориулалтаар идлэг шонхор шувуу бариулах гэрээ
4. Гэрээний хавсралт “Идлэг шонхор барих үйл ажиллагаанд оролцох иргэдийн жагсаалт, Идлэг шонхор барих үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслийн жагсаалт
5. Идлэг шонхор шувуу барьсан тухай актын загвар

Хувийг: Аймгийн Тагнуулын газар, Цагдаагийн газарт



Сүхбаатар аймгийн байгаль орчин, аялал
жуулчлалын газар
Захиргаа
Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Шархүү Нямхүү

2024-08-19 14:52:17